

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын
2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
196 дугаартай албан бичгийн 1 дүгээр хавсралт

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2022 оны жилийн эцсийн байдлаар/

2022 оны 12 дугаар сарын 23

Багануур дүүрэг


Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо					Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр			Өргөдлийн төрөл				
			Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	1-10 хоногт	11-20 хоногт	21-30 хоногт	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо	Албан бичгээр	Утсаар	Биечлэн уулзах	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Ажил хүссэн	1			1							+			+		
2	Дэмжлэг туслалцаа хүссэн																
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой																
4	Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл	2			2							+			+		
5	Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл																
6	Бусад																
	Нийт	3			3							3			3		

Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

№	Ангилал	Тоо	Шалтгаан, тайлбар
0	1	2	3
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	3	- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т Захиргааны Албаны Ахлах мэргэжилтэн ажилтай Э.Энхзаяа Улаанбаатар хот руу шилжих болсон тул ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. БҮТП ОНӨТҮГ-ын даргын 2022 оны 04 сарын 01-ний өдрийн Б/03 тушаалаар ажлаас чөлөөлөв. - “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т жолооч ажилтай Дамбачимэдийн Бат-Эрдэнэ ар гэрийн шалтгаанаар Хэнтий аймаг руу буцаад нүүх болсноор ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул БҮТП ОНӨТҮГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Б/09 дугаартай тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлсөн. - Иргэн Баясалын Саруул Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-т жолоочоор ажиллах хүсэлт гаргасан. БҮТП ОНӨТҮГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Б/10 дугаартай тушаалаар ажилд авав.
2	Боломжгүй тухай хариу өгсөн	-	-
3	Бусад	-	-

ХЯНАСАН:


“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД ХАРИЛЦАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХДУЛАМ

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-Т ИРГЭД,
АЛБАН ХААГЧДААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2022 ОНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 23

Багануур дүүрэг

1. Манай байгууллагад 2022 онд иргэдээс ажилд орох хүсэлтэй өргөдөл 1, ажлаас чөлөөлөгдөх утгатай 2 өргөдөл ирсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал өргөдөл хүсэлтийн төрлийн хувьд адилхан, тооны хувьд 1-ээр цөөн байна. Өргөдлийг өдөр, өдөрт нь иргэн, албан хаагчдын хүсэлт ёсоор, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын даргын тушаалаар тус тус шийдвэрлэсэн. Өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар манай байгууллагад 4 өргөдөл, тухайлбал 1 иргэнээс ажилд орох хүсэлт, 1 ажилтан ажлаас чөлөөлөгдөх, 2 ажилтан ковидын улмаас цахимаар ажиллах хүсэлт гаргасныг тус бүр хүсэлтийн дагуу өдөр, өдөрт нь багтаан шийдвэрлэсэн байна.

Тайлант онд иргэд албан хаагчдаас ирүүлсэн 3 өргөдлийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтөлж, өргөдлүүд болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн тус тус архивлахад бэлтгэсэн.

Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна.

2. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

3. Бүтээлч санал санаачлагын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. 2022 оны байдлаар байгууллагын удирдлага нийт 25 иргэнтэй уулзсан байна.

Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачлагын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл нь Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан гэрээ юм. МЕСЕС ХХК-тай хамтран хэрэгжүүлэх Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 6,76км урт 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих ажлын нийт 3,922.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 45%-ийг тус компаниас, 55%-ийг нийслэлийн төсвөөс шийдвэрлүүлэхээр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт талаас уг ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг ханган ажилласан. Улмаар МЕСЕС ХХК-ийн зүгээс 526,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурийн барилгын ажил хийж, 500.0 сая төгрөгийн бетон болон төмөр тулгуур бэлтгэх ажил хийсэн байна.

“Импактор Капитал Менежмент Монголия” ХХК-иас Паркийн хүрээнд, уурхайн хаягдал нүүрсийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийн санал ирүүлснээр Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд Казахстан, Герман, Монгол Улсын хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх “Импактор Капитал Менежмент Монголия” ХХК-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд цахим болон нүүр тулсан уулзалтууд зохион байгуулж, уг төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар зөвшилцсөн. Төсөл хэрэгжүүлэгчид эрчимтэй ажиллаж

байгаа тул тэдний санал хүсэлтийг, Паркийн ХЕТ-д тусгуулах арга хэлбэрийг эрэлхийлэн холбогдох удирдлагуудад хүргүүлэх томоохон ажил яаралтай шийдвэрлэх шаардлагууд гарсан, хийж гүйцэтгэсэн.


4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.

5. Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН

ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН




Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД ХАРИЛЦАА

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХДУЛАМ